ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



2026 June

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ 1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ 2

2.1. Олон улсын эдийн засаг 2

2.2. АНУ-ын эдийн засаг 2

2.3. БНХАУ-ын эдийн засаг 3

2.4. Түүхий эдийн зах зээл 4

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ 6

3.1. Эдийн засгийн өсөлт 6

3.2. Инфляц 7

3.3. Улсын төсөв 7

3.4. Мөнгөний нийлүүлэлт 8

3.5. Нийт зээл 9

3.6. Гадаад худалдаа 10

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш 13

График, хүснэгтүүдийн жагсаалт

График 1 АНУ-ын инфляц, гадаад худалдаа 5
График 2 БНХАУ-ын үнийн индекс, гадаад худалдаа 5
График 3 Монгол улсын эдийн засгийн өсөлт 6
График 4 Инфляц ба Бодлогын хүү 7
График 5 Улсын төсөв 8
График 6 Мөнгөний нийлүүлэлт 9
График 7 Банкны салбарын зээл 10
График 8 Нийт экспорт ба импорт 10
График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн 10
График 10 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин 11
График 11 Чулуун нүүрснйи экспортын биет хэмжээ, үнийн түвшин 11
График 12 Импортын голлох бүтээгдэхүүн 12
График 13 Төлбөрийн тэнцэл 13

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026Q1	**2025Q4**	**2025Q1**	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	6,736	34,332	6,244	7.9%
Ажилгүйдлийн түвшин	%	5.7%	5.6%	5.4%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,921	2,852	2,622	11.4%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M5	**2026M4**	**2025M5**	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	8,471	6,813	5,398	56.9%
Зэс	сая ам.доллар	3,807	3,080	1,853	105.5%
Нүүрс	сая ам.доллар	3,201	2,515	2,198	45.6%
Нийт импорт	сая ам.доллар	4,905	3,669	4,538	8.1%
Хэрэглээ	сая ам.доллар	1,375	1,066	1,565	-12%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	1,878	1,350	1,788	5.0%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	469	372	342	37.0%
Шатахуун	сая ам.доллар	1,174	872	837	40.0%
Тэнцэл	сая ам.доллар	3,565	3,145	861	4.1x
Түүхий эдийн үнэ (Primary Commodity Prices, IMF, Монголбанк)					
Зэс	$/тонн	13,484	12,891	9,531	41.5%
Нүүрс (хилийн)	$/тонн	72.0	68.6	67.0	7.5%
Алт	$/трой унц	4,578	4,720	3,288	39.2%
Газрын тос	$/баррел	106	103	64	65.8%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M5	**2026M4**	**2025M5**	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	-1,351	-1,425	-260	420%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	11,672	8,947	10,712	9%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	13,023	10,372	10,971	25.6%
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	52,000	50,685	40,773	27.5%
ХҮИ (С2023)	индекс	127.1	125.6	114.4	11.2%
Бодлогын хүү	%	12%	12%	12%	-
Хүү ба ханш					
Нэрлэсэн ханш (хугацааны эцэст)	Төгрөг/$	3,576	3,576	3,573	0.1%
Төгрөгийн хадгаламж (тухайн сард шинээр татсан)	%	11.75%	11.88%	11.88%	-1.1%
Валютын хадгаламж (тухайн сард шинээр татсан)	%	4.24%	4.19%	3.66%	15.9%
Төгрөгийн зээл (Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү)	%	17.50%	17.53%	17.18%	1.88%
Валютын зээл (Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү)	%	10.34%	10.08%	10.91%	-5.17%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	7,733	7,327	5,194	48.9%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засаг



2026 оны 6-р сарын байдлаар Иран болон АНУ-ын хооронд үүссэн зөрчил хурцадмал байдал намжиж эхлээд байна. АНУ болон Иран ойрын хугацаанд харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурахаар төлөвлөж байгаа бөгөөд уг баримт бичиг нь ирэх 60 хоногийн турш өрнөх иж бүрэн хэлэлцээний эхлэлийг тавих юм. Энэ хэлэлцээгээр хоёр улсын хоорондын зэвсэгт мөргөлдөөнийг бүрэн зогсоох, мөн Ираны цөмийн хөтөлбөрт шинэ хязгаарлалтууд тогтоох асуудлыг хэлэлцэхээр зорьж байна.

Санамж бичигт дайныг нэн даруй бөгөөд бүрмөсөн зогсоосныг тунхаглаж, АНУ өөрийн тавьсан тэнгисийн бүслэлтийг цуцлах, бүс нутгийн ойролцоох цэргийн хүчээ татан гаргах зэрэг заалтууд багтжээ. Түүнчлэн уг хэлэлцээр нь АНУ-аас Ираны эсрэг авсан хориг арга хэмжээнүүдийг үе шаттайгаар цуцлах амлалт, Ираны эдийн засгийн хөгжлийг дэмжих санхүүжилт олгох, улмаар тус улсын эдийн засгийг сэргээх урт хугацааны төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлэх зэрэг чухал заалтуудыг агуулж байна. Ийнхүү хоёр талын харилцаа дайсагналын үе шатаас аажмаар гарч, дипломат замаар асуудлыг шийдвэрлэх шинэ шат руу шилжиж эхэлж байна.

Ийнхүү гал зогсоох хэлэлцээрийн мэдээллээр нефтийн үнэ буурч, 5-р сарын байдлаар 100–107 ам.доллараас 80–90 ам.долларын түвшинд хүрээд байна. Гэсэн ч 2026 онд дэлхийн газрын тосны нийлүүлэлт өдөрт ойролцоогоор 3.9 сая баррелиар буурах төлөвтэй бөгөөд 2027 оноос бүрэн сэргэх хүлээлттэй байна.

2.2. АНУ-ын эдийн засаг

График 1 АНУ-ын инфляц, гадаад худалдаа

АНУ-ын эдийн засгийн өсөлт
жилийн өсөлтийн хувь



Эх сурвалж: U.S. Bureau of Labor Statistics

АНУ-ын инфляц
жилийн өсөлтийн хувь



Эх сурвалж: U.S. Bureau of Labor Statistics

АНУ-ын эдийн засгийн жилийн өсөлт 2026 оны 1-р улиралд 2.7 хувьтай гарсан ба өмнө жилийн мөн үеэс 0.7 нэгж хувиар өндөр гарсан үзүүлэлттэй байна. Гэвч энэ өсөлт инфляцын дарамттай зэрэгцсэн бөгөөд 2026 оны 5-р сарын инфляцын түвшин 4.2 хувь гарсан нь Төв банкны зорилтот 2 хувийн түвшнээс даруй 2.2 нэгж хувиар өндөр түвшин болж байна. Ийнхүү Холбооны Нөөцийн Банк (Fed) 2026 оны 6-р сард болсон хурлаараа бодлогын хүүгээ 3.50%–3.75% түвшинд өөрчлөлтгүй хадгалсан бөгөөд энэ нь зах зээлийн хүлээлттэй нийцсэн шийдвэр байлаа. Ирээдүйн эдийн засгийн хүлээлтийн хувьд 2026 оны эдийн засгийн өсөлтийн таамаг 2.4%-иас 2.2% хүртэл буурсан бол 2027 оны өсөлтийг 2.3% хэвээр хадгалсан байна. Харин инфляцын төлөв мэдэгдэхүйц өссөн бөгөөд 2026 оны эцэст 3.8% буюу зорилтот түвшнээс өндөр, харин 2027 оны 1-р улирлаас 3.3% болж саарах төлөв ажиглагдаж байна.

2.3. БНХАУ-ын эдийн засаг

График 2 БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, инфляц



Эх сурвалж: National bureau of statistics of China



Эх сурвалж: National bureau of statistics of China

БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний улиралд 5 хувийн өсөлт үзүүлсэн нь дэлхийн том эдийн засгууд дунд харьцангуй өндөр хэвээр байна. Гэхдээ энэ өсөлт нь голлон үйлдвэрлэл, экспорт, технологийн салбараас хамааралтай бөгөөд дотоод хэрэглээ, үл хөдлөх хөрөнгийн захын идэвхжил сул хэвээр байна. Цаашдын төлөвийг авч үзвэл, Хятадын эдийн засгийн өсөлт 2026 онд ойролцоогоор 4.5 хувь, 2027 онд 4 орчим хувь хүртэл аажмаар саарах хандлагатай байна. Нэг талаас эдийн засгийн өсөлтийг алгуур сааруулж чанарт суурилсан өсөлтийг бий болгох бодлогын зорилтыг дэвшүүлсэн ч, эдийн засгийн идэвхжил нь гадаад эрэлтийн тодорхой бус байдал болон дотоод бүтцийн асуудлуудтай холбоотойгоор сул хэвээр байгаа юм.

Инфляцын хувьд, 2026 оны 5-р сарын байдлаар 1.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеийн -0.1 хувьтай харьцуулахад мэдэгдэхүйц өссөн үзүүлэлттэй гарсан байна. Энэхүү өсөлт нь эрэлтийн шинжтэй үнийн өсөлтөөс илүүтэй олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалж үйлдвэрлэгчдийн үнийн индекс өссөнтэй уялдсан зардлын шинжтэй инфляцын дарамт болж байна.

2.4. Түүхий эдийн зах зээл

Дэлхийн банкны 2026 оны 6 дугаар сарын “Түүхий эдийн зах зээлийн төлөв” тайланд Ойрх Дорнодын зөрчилдөөнтэй холбоотойгоор түүхий эдийн зах зээлд үүсч буй эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдал болон ирээдүйн үнийн таамаглалын тухай танилцууллаа. Тайланд дэлхийн түүхий эдийн үнийн индекс энэ онд ойролцоогоор 16 хувиар өсөх төлөвтэй байгааг онцолсон ба энэ нь олон улсын түвшинд үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлэх, инфляцыг өдөөх суурь шалтгаан болж байна.

Ийнхүү түүхий эдийн үнийн суурь индекс өсөх нь зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсаныг илэрхийлж байгаа ба өсөлтийн гол шалтгаан нь нийлүүлэлтийн саатал, тээврийн тасалдал, мөн зах зээлд тодорхой бус байдал давамгай байгаатай холбоотой.

Олон улсын байгууллагуудын дүгнэлтээр 2026 он нь түүхий эдийн зах зээлд үнэ огцом өссөн, хэлбэлзэл өндөртэй үе байх бол 2027 онд нийлүүлэлт аажмаар сэргэж, зах зээл хэсэгчлэн тогтворжих хандлага ажиглагдах төлөвтэй байна.

Хүснэгт 1 Түүхий эдийн үнийн төсөөлөл

Түүхий эд	Спот үнэ	2026Q2	2026Q3	2026Q4	2027Q1	2026	2027
Брэнт газрын тос, $/баррель	$76	$107	$94	$86	$82	$94	$79
Зэс, $/тонн	$13,814	$13,516	$13,659	$13,660	$13,661	$13,424	$13,665
Алт, $/унц	$4,320	4,555	4,575	4,624	4,673	4,676	4,752
Австралийн эрчим хүчний нүүрс, $/сая тонн	$143	$136	$135	$130	$133	$135	$115

Эх сурвалж: Bloomberg Terminal, World Bank

Алт: Алтны үнэ 2025 оны сүүлээс эхлэн огцом өсөлтийг үзүүлсэн ба 2026 оны 1-р улирал гэхэд өмнөх жилтэй харьцуулахад 17%-иар өссөн. 2026 оны 2-р сард алтны үнэ нэг унц нь $5,000-аас давсан дээд түвшинд хүрсэн ч дайны нөхцөл байдал, ХНБ-ны хүү буурахгүйгээс долларын өгөөж өндөрт хадгалагдсантай холбоотойгоор 4-р сараас алтны ханш буурах хандлагатай байв. Цаашид геополитикийн тодорхой бус байдал, инфляцын дарамт, бодит хүүгийн түвшин буурах боломж зэрэг нь алтны эрэлтийг дэмжиж, үнийг 2027 он хүртэл өндөр түвшинд хадгалах төлөвтэй байна.

Зэс: Металл, ашигт малтмалын зах зээл 2026–2027 онд хамгийн хүчтэй өсөлттэй сегментүүдийн нэг байх төлөвтэй байна. Ялангуяа зэс зэрэг үйлдвэрлэлийн гол орц болох металлууд эрчим хүчний шилжилт, дижитал эдийн засаг, хиймэл оюуны дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалан эрэлт өндөр хэвээр байх болно. Иймд металлын зах зээлд нийлүүлэлтийн хязгаарлалт, стратегийн эрэлт (жишээлбэл батарейн түүхий эдүүд) үргэлжлэн үнийг өндөр түвшинд хадгалах ба зэс 2026 онд тонн тутамд $13,424, харин 2027 онд $13,665 болж өсөх төлөвтэй байна.

Газрын тос: Ойрх Дорнодоос эрчим хүчний экспорт буурсны нөлөөгөөр 2026 онд эрчим хүчний индексийн үнэ өмнөх оноос 24%-аар өсөх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь Дэлхийн банкны 1-р сард гаргасан газрын тосны үнийн таамаглалаас ойролцоогоор 40%-аар өндөр дүн болж байна.

Газрын тосны үнэ 2026 оны эхний хоёр сард $69/баррель байсан ч 3–4 дүгээр сард ~$100 хүрч огцом өссөн бөгөөд нийлүүлэлт хомс хэвээр байгаа тул ойрын хугацаанд өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй. Гэсэн хэдий ч зах зээл дэх нөөц (хадгалалт болон тээвэрт буй нефть) тодорхой хугацаанд хэрэглээг дэмжиж байна. Хэрэв оны хоёрдугаар хагаст Ойрх Дорнодын экспорт сэргэвэл брэнт газрын тосны үнэ 2026 онд дунджаар $86/баррель, 2027 онд $70 орчим хүртэл буурах төлөвтэй байна.

Өндөр үнийн нөлөөгөөр газрын тосны хэрэглээ бага зэрэг буурч эхэлсэн бөгөөд ялангуяа Азид шатахууны хэрэглээ удааширч байна. Үүний зэрэгцээ дэлхийн газрын тосны үйлдвэрлэл 2026 онд 1.5%-иар буурах төлөвтэй байгаа ч нөхцөл байдал тогтворжвол OPEC болон бусад олборлогчдоос нийлүүлэлт нэмэгдэж, оны сүүлээр зах зээлд илүүдэл үүсэх боломжтой гэж Дэлхийн банкны 4-р сарын “Түүхий эдийн зах зээлийн төлөв” тайланд тодотгожээ.

Нүүрс: Нүүрсний зах зээлд эрчим хүчний эрэлт нэмэгдсэн нөлөөгөөр 2026 онд үнэ өсөх хандлагатай байгаа бөгөөд Австралийн эрчим хүчний нүүрсний үнэ өмнөх оноос 20%-аар өсөх, харин 2027 онд эргээд 12%-аар буурах төлөвтэй байна. Байгалийн хийн нийлүүлэлт хомсдсоноор эрчим хүчний салбарт нүүрсээр тодорхой хэмжээг орлуулах хандлага ажиглагдаж байгаа ба нэн ялангуяа Азид дулааны нүүрсний эрэлт нэмэгдэхээр байна.

Газрын тос, байгалийн хийн нийлүүлэлтийн доголдлоос шалтгаалж нүүрсний эрэлт богино хугацаанд нэмэгдээд буй хэдий ч дунд хугацаанд сэргээгдэх эрчим хүчний шилжилттэй холбоотойгоор дэлхийн нүүрсний үйлдвэрлэл буурах хүлээлт хэвээр байна.

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт

2026 оны эхний дөрвөн сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол улсын эдийн засгийн өсөлт 7.8%-д хүрч өмнөх оны мөн үеийн 5.6%-ийн өсөлтөөс сайжирсан үзүүлэлт болж байна.

График 3 Монгол улсын эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ийнхүү өсөхөд уул уурхай, олборлолтын салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.0%-аар, хөдөө аж ахуйн салбар 11.4%-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Салбарын оролцооны хувиар авч үзэхэд нийт эдийн засгийн өсөлтийн 4.0 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 2.1 нэгж хувийг тээвэр, үйлчилгээний салбар бүрдүүлсэн бол удаалж 1.3 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар дангаар бүрдүүлсэн байна[2].

Хүснэгт 2 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны эхний дөрвөн сарын байдлаар

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	**7.8%**	
ХАА	1.3%	11.4%
Уул уурхай, олборлолт	**4.0%**	**30.0%**
Үйлдвэрлэл, барилга	0.3%	2.9%
Тээвэр, үйлчилгээ	2.1%	4.2%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.1%	0.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

[2] *Голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр авч үзэхэд өмнөх оны мөн үеэс нүүрсний олборлолт 42.3%-аар, харин зэсийн баяжмалын үйлдвэрлэл 29.6%-аар өссөн байна.*

3.2. Инфляц

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны 5 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.2%, өмнөх сараас 1.2%-аар тус тус өсч, инфляц эрчимжих хандлага үргэлжилж байна.

Жилийн инфляцыг бүрэлдэхүүнээр авч үзвэл өсөлтийн голлох дарамт хүнсний бүлгээс үүссэн хэвээр байна. Тухайлбал, хүнсний барааны үнэ өмнөх оны мөн үеэс 23.4%-аар өсөж, нийт инфляцын 6.4 нэгж хувь буюу 57.3%-ийг бүрдүүлсэн нь хамгийн өндөр нөлөө үзүүлжээ. Ялангуяа мах, махан бүтээгдэхүүний үнэ огцом өссөн нь инфляцын өсөлтийн гол хүчин зүйл болсон бөгөөд 2026 оны 5 дугаар сард үхрийн мах 54.6%, хонь, ямааны мах 53.4%-аар тус тус өсч мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 46.7%-аар өссөн байна.

График 4 Инфляц ба Бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн өсөлттэй холбоотойгоор зарим төрлийн шатахууны бүтээгдэхүүний үнэ өсч нийт инфляцын 1.0 нэгж хувийг тайлбарлаж байгаа бол шатахуунаас бусад импортын барааны үнийн өсөлт инфляцад 1.8 нэгж хувийн нөлөө үзүүлжээ. Харин махнаас бусад дотоодын бараа үйлчилгээний үнэ 3.9 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Ийнхүү инфляц оны эхэнд зорилтот интервалд хадгалагдаж байсан хэдий ч хоёрдугаар улирлаас эхлэн дахин эрчимжиж, Төв банкны зорилтот интервалыг даван өндөр түвшинд хүрээнд байгаа нь мөнгөний бодлого хатуу төлөвт хадгалагдах нөхцөлийг үүсгэж байна.

3.3. Улсын төсөв

2026 оны эхний 5 сард улсын төсвийн орлого өссөн ч зарлага илүү хурдтай нэмэгдэж, алдагдал огцом тэллээ. Улсын нийт тэнцвэржүүлсэн орлого 11.7 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 9.0%-иар өссөн бол нийт зарлага 13.0 их наяд төгрөгт хүрч 18.7%-

аар өссөнөөр тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн алдагдалд хүрч, өмнөх оны мөн үеэс 5 дахин нэмэгдээд байна.

Төсвийн зардлын бүтцийн гол бүрэлдэхүүнүүдийн өсөлтийг харвал, 2026 оны эхний 5 сард нийт зардалд хамгийн өндөр жин эзэлж буй урсгал шилжүүлэг (41.0%) өмнөх оны мөн үеэс 7.1%-иар өссөн байна. Үүний дараа нийт зардлын 36.6%-ийг бүрдүүлж буй бараа, үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 17.5%-иар өссөн нь төсвийн зардлын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Харин нийт зардлын 14.4%-ийг эзэлж буй хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс 72.5%-иар огцом өссөн нь нийт зардлын өсөлтийг дэмжив.

График 5 Улсын төсөв



Эх сурвалж: УСХ

Харин улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 30.5%-ийг орлогын албан татвар, 23.6%-ийг НӨАТ, 22.7%-ийг нийгмийн даатгалын орлого, 7.3%-ийг гадаад үйл ажиллагааны орлого, 3.2%-ийг онцгой албан татвар тус тус бүрдүүлсэн байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого 9.0%-иар өсөхөд нийгмийн даатгалын орлого 16.7%, НӨАТ 9.8%-иар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол орлогын албан татвар 0.6%, онцгой албан татвар 28.2%-иар буурсан нь өсөлтийг сааруулжээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлт хэдий эерэг байгаа ч энэ нь голчлон НӨАТ болон нийгмийн даатгалаас хамаарч, орлогын албан татвар болон онцгой албан татвар буурсан нь орлогын өсөлтийн тогтвортой байдлыг сулруулж байна.

Иймд төсвийн алдагдал тэлж буй нь зөвхөн зардлын өсөлтөөс шалтгаалахаас гадна орлогын өсөлтийн тогтвортой байдал сул байгаатай холбоотой байна. Цаашид зардлын үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ орлогын суурийг өргөжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

3.4. Мөнгөний нийлүүлэлт

2026 оны 5-р сард мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.3%-иар өсөж 52 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хувь сүүлийн 6 сарын турш дараалж өсөж байгаа бөгөөд 5-р сард эх үүсвэр (пассив) талаас төгрөгийн хадгаламжийн өсөлт нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, төгрөгийн хадгаламж 28.1 их

наяд төгрөгт хүрч өмнөх оноос 5.9 их наяд төгрөгөөр буюу 26.6%-иар өссөн бол төгрөгийн харилцах 11.6 их наяд төгрөгт хүрч 2.9 их наяд төгрөгөөр буюу 32.7%-иар, валютын харилцах 5.7 их наяд төгрөгт хүрч 2.2 их наяд төгрөгөөр буюу 59.8%-иар тус тус өссөн байна. Харин валютын хадгаламж 5.7 их наяд төгрөгт хүрч 220.6 тэрбум төгрөгөөр буюу 4.2%-иар өссөн байна. Төгрөгийн хадгаламжийн 81.9%-ийг иргэдийн хадгаламж, 18.1%-ийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд байршуулалт (актив) талаас гадаад валютын цэвэр орох урсгал сайжирч гадаад цэвэр активын өсөлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, гадаад валютын харилцах 2026 оны 5 дугаар сард 5.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 их наяд төгрөгөөр буюу 59.7%-иар өссөн байна.

График 6 Мөнгөний нийлүүлэлт



Эх сурвалж: УСХ

3.5. Нийт зээл

Нийт зээлийн үлдэгдэл 2026 оны 5-р сард 47.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.9 их наяд төгрөгөөр буюу 17.1%-аар өссөн бол өмнөх сараас 1.3 их наяд төгрөгөөр буюу 3%-аар өсчээ. Нийт зээлийн 5.3% буюу 2.5 их наяд төгрөг нь чанаргүй зээл байгаа бөгөөд хэмжээний хувьд өмнөх оны мөн үеэс 18.2%-иар өсжээ. Харин анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.8%-аар мэдэгдэхүйц буурсан ба нийт зээлийн 2.7%-ийг бүрдүүлж байна.

Зээлийн бүтцийн хувьд нийт зээлийн 64.7% нь бизнесийн зээл, 24.4% нь иргэдийн зээл, үлдсэн 10.8% нь банкны эх үүсвэрээр олгосон ипотекийн зээл байна. Мөнгөний бодлого хатуу төлөвт хадгалагдаж байгаа нөлөөгөөр зээлийн өсөлт 2025 оны эхэн үеэс алгуур саарч 2026 оны 5-р сарын байдлаар 17.1%-д хүрээд байна. Үүнээс хэрэглээний зээлийн өсөлт илүү саарч 9.1%-д хүрсэн бол бизнесийн зээлийн өсөлт 17.2%-д хүрч нийт зээлийн өсөлтийг голлон дэмжжээ.

График 7 Банкны салбарын зээл



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

3.6. Гадаад худалдаа

2026 оны эхний таван сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 8,471 сая ам.долларыг давж өмнөх оны мөн үеэс 56.1%-аар өссөн бол нийт импорт 4,905 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 8.0%-аар өсжээ. Сүүлийн саруудад шатахууны үнийн өсөлт болон олон улсын геополитикийн тодорхойгүй нөхцөл байдлаас шалтгаалж импортын зардал өсөх хандлагатай байгаа бол нүүрс болон зэсийн баяжмалын экспортын өсөлтөөр нийт экспортын өндөр өсөлт хэвээр хадгалагдаж байна. Улмаар худалдааны ашиг эхний таван сард 3.6 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны ашгаас 4 дахин өндөр байгаа юм..

График 8 Нийт экспорт ба импорт



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Экспортын 56.1 хувийн өсөлтийн 36.0 нэгж хувийг зэсийн баяжмалын орлогын өсөлт, харин 18.5 нэгж хувийг нүүрсний экспортын орлого тайлбарлаж буй. Тухайлбал өмнөх

оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын орлого хоёр дахин өссөн бол, нүүрсний экспортын орлого 45.6%-аар, мөн алтны экспортын орлого 22.8%-аар өсөөд байна.

График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Зэсийн баяжмалын биет хэмжээ эхний таван сард 1,089 мянган тоннд хүрсэн ба сарын цэвэр хилийн үнэ тонн тутамд 3,647 ам.долларт хүрснээр өмнөх сараас ялимгүй буурсан ч өмнөх оны мөн үеэс 54.9%-аар өсжээ. Монгол улсын зэсийн баяжмалын олборлолт өмнөх оны сүүлийн хагасаас эрчимтэй сэргэж, цаашид ч зэсийн үйлдвэрлэл өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй бөгөөд сэргээгдэх эрчим хүч, орчин үеийн боловсронгуй аж үйлдвэрлэл нь зэсийн эрэлтийг дэмжсэнээр дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ дунд хугацаанд өндөрт хадгалагдах төлөвтэй байна.

График 10 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 5-р сар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Харин нүүрсний хувьд 5-р сард үнэ өсөх хандлага ажиглагдлаа. БНХАУ-ын нүүрс олборлолтын Шаньси муж дахь Люшэньюү уурхайд хий дэлбэрч хүний амь нас

эрсэдсэн хэрэг явдлаас шалтгаалж дотоод хяналт шалгалтын ажил эрчимтэй хийгдэж эхэлсэн. (Sxcoal, 2026)

Улмаар дотоод уурхайнуудын үйл ажиллагаа саатаж нийлүүлэлт тасалдсанаар үнийн өсөлт бий болж, Монгол улсын экспортлох нүүрсний хилийн үнэ тонн тутамд 72 ам.долларт хүрч өмнөх сараас 3.4 ам.доллароор өсөөд байна. Биет хэмжээний хувьд ч өмнөх оноос 48.0%-ийн өсөлттэй буюу 47 сая тонн-д хүрч нүүрсний экспортын орлого 3.2 тэрбум ам.долларыг давснаар нийт экспортын орлогын 37.8%-ийг бүрдүүлжээ.

График 11 Чулуун нүүрснйи экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 5-р сар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Цаашлаад импортын зардлын задаргааны хувьд нефтийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 40.3%-аар өссөн бол бусад суудлийн болон ачааны автомашины импорт өмнөх оны мөн үеэс бууралт өндөртэй байна. Нефтийн бүтээгдэхүүний өсөлтийг бүрэлдэхүүн хэсгээр авч үзэхэд нийт өсөлтийн 29.9 нэгж хувийг зуны дизель түлш, харин 10.1 нэгж хувийг АИ 92 бензиний худалдан авалт голлон бүрдүүлжээ.

График 12 Импортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: : Гаалийн Ерөнхий Газар

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш

2026 он гарснаас хойш гадаад худалдааны нөхцөл байдал тогтвортой сайн хадгалагдсанаар урсгал дансны хуримтлагдсан ашиг нэмэгдэж 4-р сарын байдлаар 311 сая ам.долларт хүржээ. Энэ нь өмнөх оны мөн үеийн 1.2 тэрбум ам.долларын алдагдлаас үнэмлэхүй сайжирсан үзүүлэлт юм. Санхүүгийн дансны орох урсгал өмнөх оны мөн үеэс суларсан ч ашигтай хэвээр буюу хуримтлагдсан дүн 227 сая ам.долларт хүрсэн байна.

Улмаар төлбөрийн тэнцэл 186 сая ам.долларын ашигтай гарч валютын нөөц үргэлжлэн нэмэгдлээ. Валютын албан нөөц 5-р сарын шинэчлэгдсэн статистикаар 7.7 тэрбум ам.долларыг давж ханш тогтвортой хадгалагдах суурь нөлөөллийг бий болгож буй. Тухайлбал төгрөгийн албан ханш 5-р сарын эцэст 3,576 төгрөг/ам.долларт хүрсэн бөгөөд цаашид харьцангуй тогтвортой хадгалагдах хүлээлттэй байна.

График 13 *Төлбөрийн тэнцэл*



Эх сурвалж: Монголбанк

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.